



## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/84

Улаанбаатар хот

Авто замын салбарын Шинжлэх ухаан,  
техникийн зөвлөлийн ажиллах журам,  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, “Зам, тээврийн хөгжлийн төв” Төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авто замын салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн ажиллах журмыг нэгдүгээр хавсралтаар, бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн үйл ажиллагааг журмын дагуу үр нөлөөтэй зохион байгуулж ажиллахыг зөвлөл /Ч.Сугармаа/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Б.Оюунчимэг /-т үүрэг болгосугай.


4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 33, 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 29 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Р.БУД

"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын  
Захирлын 2020 оны 02-р сарын 06-ны  
өдрийн А/дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт



## АВТО ЗАМЫН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Авто замын салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ - ийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Зөвлөл нь авто замын салбарын хүрээнд Шинжлэх ухаан, инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх, дэвшилтэт техник технологи, материалыг авто замын үйлдвэрлэлд нэвтрүүлэх, нутагшуулахтай холбоотой асуудал, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, хуулийн этгээд эрхлэн хийсэн эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, зохион бүтээх ажлын явц, үр дүн, авто зам, замын байгууламжийн хайгуул, зураг төслийн ажил, техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа, барилга угсралт, засвар арчлалт, норматив техникийн баримт бичгийн төсөл, тайлан, тэдгээртэй холбоотой инженерийн шийдэл бүхий нарийн төвөгтэй асуудлыг тус тус хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгч, зөвлөмж гаргана.

1.3 Зөвлөл нь "Иргэний тухай" хууль, "Шинжлэх ухаан, технологийн тухай" хууль, "Авто замын тухай" хууль, "Инновацийн тухай" хууль, "Технологи дамжуулах тухай" хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг мөрдөн, энэхүү журмын дагуу үйл ажиллагаа явуулан, дүгнэлт, зөвлөмж /шийдвэр/-өө бие даан хараат бус байдлаар гаргана.

1.4 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хурал байна. Зөвлөлийн хурлыг цаг үеийн шаардлагыг харгалзан тухай бүрд нь хугацаа харгалзахгүй зарлан хуралдуулна. Зөвлөл нь зохих журмын дагуу хийсэн албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.5 Зөвлөл нь орон тооны бус хэлбэрээр ажиллах бөгөөд зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг Төвийн захирлын тушаалаар баталж, томилно.

1.6 Зөвлөл нь Зам, тээврийн хөгжлийн яам /Цаашид "Яам" гэх/-ын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн авто замын асуудал эрхэлсэн дэд зөвлөл байна.

1.7 Зөвлөлийн хурлыг хэлэлцэх асуудлын цар хүрээнээс хамааруулан шаардлагатай гэж үзвэл хэлэлцүүлэх асуудлын талаар мэдлэгтэй Яам болон холбогдох бусад байгууллагын удирдах албан тушаалтан, мэргэжилтнүүд, салбарын эрдэмтэд, Зөвлөх инженерүүд, бусад салбарын мэргэжилтнүүдийг зөвлөлийн даргын зөвшөөрлөөр урьж оролцуулж болно.

### Хоёр. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

2.1 Зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Бүрэлдэхүүн нь 18 гишүүнтэй байх ба Авто замын болон бусад салбарын байгууллагад ажиллаж байгаа авто замын салбарын мэргэжлийн өндөр мэдлэгтэй, дадлага туршлага бүхий авто зам, замын байгууламжийн норматив баримт бичиг, хайгуул зураг төсөл төлөвлөлт, материал, эдийн засаг үнэ бүрдэлт төсөв болон ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлийн эрдэмтэд,

инженер, эдийн засагч, инженер механик нарыг эрхэлж буй ажил үүрэг харгалзахгүйгээр оролцуулна.

2.2 Зөвлөлийн бүрэлдэхүүний 70-аас доошгүй хувь нь эрдмийн зэрэг цолтой, зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй, авто замын салбарт мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан дадлага, туршлагатай байна.

2.3 Зөвлөлийн хурлыг Зөвлөлийн дарга удирдана. Зөвлөлийн даргын эзгүйд түүний зөвшөөрлөөр хурлыг Дэд дарга удирдан явуулна.

2.4 Асуудал хэлэлцүүлж буй байгууллага, зөвлөлийн гишүүд болон урилгаар оролцож буй гишүүд хурлын явцад дуу болон дүрс бичлэг хийхийг нарийн бичгийн даргад мэдэгдэж, хурал удирдагчаас зөвшөөрөл авна.

2.5 Хуралд нийт гишүүдийн 75-аас дээш хувь нь оролцсон тохиолдолд хурал хүчин төгөлдөрт тооцогдож, санал хураалтад оролцох гишүүдийн олонхийн саналыг үндэслэн хурлын шийдвэр хүчинтэй болно. Шийдвэр нь зөвлөмжийн чанартай байна.

2.6 Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй тохиолдолд энэ тухай хурал болохоос 1 хоногийн өмнө зөвлөлийн дэд даргад мэдэгдэж чөлөө авна.

2.7 Чөлөө авсан гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулж, өөрийн саналаа баталгаажуулан 1 хоногийн өмнө бичгээр эсвэл цахим шуудангаар нарийн бичгийн даргад урьдчилан ирүүлсэн тохиолдолд саналын тоонд оролцуулан тооцно.

2.8 Зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүн тус бүр саналын нэг эрхтэй байх бөгөөд дүгнэлт, зөвлөмжөө хуралд оролцсон санал хураалтад оролцох гишүүдийн дийлэнх олонхийн саналыг үндэслэн гаргана.

2.9 Асуудал хэлэлцүүлж буй тус зөвлөлийн гишүүн, тэдний багт ажилласан зөвлөлийн гишүүний саналыг тус тус санал хураалтад тооцохгүй.

2.10 Зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүн нь жилийн нийт хурлын 30%-д нь хүндэтгэх шалтгаангүйгээр оролцоогүй, эсвэл зөвлөлийн хурлын үйл ажиллагаанд идэвх санаачлагагүй оролцдог, үйл ажиллагааны журмыг удаа дараа зөрчсөн бол зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх үндэслэл болно.

2.11 Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх асуудлыг журмын 2.12 дэх заалтыг үндэслэн Төвийн захиралд уламжлан шийдвэрлүүлнэ.

2.12 Шинэчлэгдсэн бүрэлдэхүүн нь зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр буюу хурлын дэгэнд өөрчлөлт оруулах эсвэл шинээр боловсруулах асуудлыг жилийн эхний хурлаараа хэлэлцэж, хурлын шийдвэрийг үндэслэн Төвийн захиралд танилцуулж, батлуулна.

2.13 Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын материалыг тухайн асуудал шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан байгууллага, төслийн баг, хувь хүн боловсруулна.

2.14 Хурлаар хэлэлцүүлэх асуудал нь дэлгэрэнгүй танилцуулга, тооцоо, зураг схем, видео бичлэг, фото зураг дээр тулгуурласан, хангалттай үндэслэлтэй, харьцуулсан хувилбар бүхий

судалгаа, дүгнэлттэй байх бөгөөд асуудлыг шийдвэрлүүлэх байгууллага, төслийн баг, хувь хүн 20 минутад багтаан товч танилцуулгыг хийнэ.

### **Гурав. Зөвлөлийн хэлэлцэх асуудлын чиглэл**

3.1 Зөвлөл нь дор дурдсан асуудлаар дүгнэлт, санал, зөвлөмж гаргана. Үүнд:

3.1.1 Авто замын салбарын шинжлэх ухаан, техник, технологийн асуудал, Монгол Улсын авто замын сүлжээг хөгжүүлэх ойрын ба хэтийн зорилт, хэрэгжүүлэх арга зам;

3.1.2 Авто зам, замын байгууламжид санал шүүмж болон зөвлөгөө өгөх;

3.1.3 Яам болон холбогдох бусад төрийн байгууллагад өргөн барих салбарын шинжлэх ухаан технологи, хүний нөөцийн хөгжил, төрөөс баримтлах бодлогын чанартай олон талт асуудлаар боловсруулсан төсөл, хөтөлбөр, санал, дүгнэлт, зөвлөмжийг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах;

3.1.4 Яам болон Төвөөс эрхлэн хэрэгжүүлэх эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн үйл ажиллагаа, авто замын салбарын норматив техникийн баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилт;

3.1.5 Төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, хуулийн этгээд, судлаачдын хийсэн эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын явц, тайлан, үр дүн;

3.1.6 Авто зам, замын байгууламжийн хайгуул, зураг төслийн ажил, техник эдийн засгийн үндэслэл, тэдгээрийн судалгааны явцад гарах инженерийн шийдэл бүхий асуудал;

3.1.7 Байгаль цаг уурын болон бусад онцгой нөхцөл байдлаас үүдсэн бүх зэрэглэл, төрлийн зам, замын байгууламжийн барилга угсралт, засвар арчлалтын ажлын өөрчлөлт, эсвэл инженерийн нарийн төвөгтэй шийдэл шаардсан асуудал;

3.1.8 Авто замын салбарт технологи дамжуулах, нутагшуулах асуудал, шинэ бүтээл, шийдэл, ашигтай загварын эрхийн хамгаалалт, баталгаажуулалтын асуудал;

3.1.9 Авто зам, гүүрийн чиглэлээр гадаад, дотоодын их, дээд сургуульд магистр болон докторын түвшинд суралцагч, инженер-судлаачдын эрдмийн бүтээлд үнэлгээ, дүгнэлт өгөх;

3.1.10 Салбарын шинжлэх ухаан техник, технологийн талаарх бодлогын хэрэгжилтийг мэдээлэх болон сурталчлах асуудал.

3.2 Асуудал шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан байгууллага, төслийн баг, хувь хүн нь Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх материалд шаардлагатай бол холбогдох байгууллага, мэргэжлийн хүмүүсээр шүүмж хийлгэж, албан ёсны санал, дүгнэлт авсан байна.

3.3 “Авто замын тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.4 болон 19.5 дахь заалтыг мөрдлөг болгон алдаатай зураг төсөлтэй холбогдох асуудлыг техникийн зөвлөл хэлэлцэхгүй.

### **Дөрөв. Зөвлөлийн гишүүдийн ёс зүй**

4.1 Зөвлөлийн хурлын үед зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүд болон урилгаар оролцож буй хувь хүн, хуулийн этгээд дараах ёс зүйн хэм хэмжээг сахина. Үүнд:

4.1.1 Зөвлөлийн гишүүд нь бие биенээ харилцан хүндэтгэн харилцана;

4.1.2 Хэлэлцэж байгаа асуудлаар маргаанд оролцохдоо өөрийн дэвшүүлж байгаа саналын үндэслэл нь эцсийн үнэнд нийцсэн санал биш гэдэг байр суурийг ямагт санаж, бусдын санаа бодлыг хүндэтгэнэ;

4.1.3 Дэвшүүлж буй санал нь дэмжигдээгүй тохиолдолд санаагаа хүнд ойлгуулах, бусдыг өөртөө итгүүлэх /үнэмшүүлэх/ тал дээр гишүүд өөрөө дүгнэлт хийх хэрэгтэй гэсэн зарчимд суурилна;

4.1.4 Аливаа асуудалд хандахдаа зорьж шийдвэрлүүлэх гэж байгаа асуудлаа төгс бодсон, өөрийн саналын дагуу шийдвэр гаргуулах гэж хэт их улайрахгүй оролцохыг чухалчлах;

4.1.5 Маргааны үед бусдын санаа бодлыг сонсох, бусдад ярих боломж олгоход анхаарч, шийдвэрийг хамтаараа гаргах тул бусдадаа мэдлэг өгч байгаа гэдгийг ямагт санах;

4.1.6 Асуудал хэлэлцүүлж буй байгууллага, төслийн баг, хувь хүн болон зөвлөлийн гишүүд энэхүү журмын 2.16, 5.4, 5.7 дугаар заалтад заасан хугацааг баримтлах;

4.1.7 Зөвлөлийн гишүүд хэлэлцэх асуудлын материалтай урьдчилан судалж, хурал эхлэхээс 5 минутын өмнө хурал зарласан газар ирсэн байх ба нарийн бичгийн дарга цаг бүртгэж, тэмдэглэл хөтөлнө.

### **Тав. Зөвлөлийн эрх, үүрэг**

5.1 Зөвлөл нь асуудал хэлэлцэх, дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг цаг тухайд нь шуурхай зохион байгуулах үүрэг хүлээнэ.

5.2 Зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүд нь дангаараа зөвлөлийг төлөөлөхгүй.

5.3 Зөвлөлийн удирдлагууд (дарга ба дэд дарга) нь хэлэлцэх асуудлын бэлтгэлийг сайтар хангуулах зорилгоор гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг томилон ажиллуулж болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл асуудлыг газар дээр нь очиж, танилцаж болно. Энэ тухай Яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад болон Төвийн захиралд танилцуулж, зөвшилцсөн байна.

5.4 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, гарсан зөвлөмж, тэмдэглэлийг ажлын 3 хоногт багтаан 2 хувь үйлдэн баталгаажуулах, 1 хувийг холбогдох газар, харьяа байгууллагад хүргүүлэх, 1 хувийг хадгалах ба хэлэлцүүлсэн материалын хамт дараа оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн дотор багтаан зохих журмын дагуу Төвийн архивд шилжүүлэх зэрэг дотоод ажлыг хариуцна.

5.5 Зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлаар хэлэлцүүлэх асуудлыг урьдчилан хянаж, хуралд оруулах саналыг Зөвлөлийн дарга болон дэд даргад танилцуулж, тэдгээрийн зөвшөөрлийг үндэслэн хурлын тов гаргаж, хурал зарлана. Хурлын тов өөрчлөгдсөн тохиолдолд хурал болохоос өмнө дор хаяж 4 цагийн өмнө зөвлөлийн гишүүдэд утсан холбоогоор болон цахим хаягаар мэдэгдсэн байна.

5.6 Хурлаас гарсан зөвлөмжид хурал удирдсан дарга, тэмдэглэл хөтөлсөн гишүүн, хурлын тэмдэглэлд хурал удирдсан дарга, дэд дарга, тэмдэглэл хөтөлсөн гишүүн гарын үсгээр баталгаажуулсан байна.

5.7 Зөвлөлийн гишүүд нь тухайн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг урьдчилан судалсан байх бөгөөд хурлын явцад хэлэлцсэн асуудалтай холбоотой асуултыг 1 минутад, саналыг 3 минутад багтаан ойлгомжтой бөгөөд цэгцтэй, үндэслэлтэйгээр хэлнэ.

5.8 Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх материал, баримт бичгийн эхийг 1 хувь, товч танилцуулга бусад материалыг хувиалан бэлтгэж, зөвлөлийн хурал хуралдахаас 7-оос доошгүй хоногийн өмнө зөвлөлийн нарийн бичгийн даргад албан бичгээр /хэвлэмэл болон цахим хэлбэрээр/ ирүүлсэн байна.

5.9 Ажлын зайлшгүй шаардлагаар нэн яаралтай хэлэлцүүлэх шаардлагатай гэж Зөвлөлийн дарга үзвэл энэ журмын 5.8-д заасан хугацааг баримтлахгүй байж болно.

5.10 Зөвлөлийн нарийн бичгийн дарга хэлэлцүүлэх асуудлын танилцуулга, тайлан, холбогдох материалыг Зөвлөлийн гишүүдэд энэ журмын 5.9-д зааснаас бусад тохиолдолд хурал болох өдрөөс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.11 Асуудал хэлэлцүүлж буй байгууллага, төслийн баг, хувь хүн нь Зөвлөлөөр асуудал хэлэлцүүлэхэд дараах материалыг Төвд хүргүүлсэн байна. Үүнд:

5.11.1 "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-т хаягласан албан хүсэлт;

5.11.2 Хэлэлцүүлэх асуудлын товч танилцуулга;

5.11.3 Судалгаа, тооцооны тайлан;

5.11.4 Ажлын даалгавар;

5.11.5 Холбогдох байгууллагуудаас санал авсан албан бичиг болон санал, дүгнэлтүүд

5.11.6 Бусад

5.12 Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын холбогдох материал, баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.12.1 Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын талаар товч танилцуулга, холбогдох материалыг энэ журмын 5.11-д заасны дагуу бэлтгэж, урьдчилан ирүүлсэн байх;

5.12.2 Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор хэлэлцсэн тухай шийдвэр, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл, 3-аас доошгүй эрдэм шинжилгээ, зураг төсөл, судалгаа шинжилгээний байгууллагын санал, мөн захиалагч, эрдэмтэн, судлаачдын санал шүүмжийг бичгээр гаргуулан авч хавсаргасан байх;

5.13 Мэргэжлийн чиглэлээр салбарын хэмжээнд бодлогын асуудал, төсөл, хөтөлбөр боловсруулагдан батлагдах үеийн техникийн төвөгшилтэй шийдэл гаргахын өмнө зөвлөлийн гишүүд заавал судалж, зөвлөмж гаргах үүрэгтэй.

5.14 Хурлын явцын гар тэмдэглэл, аудио бичлэг болон видео бичлэгийг зөвлөлийн гишүүдэд шууд, бусад албан тушаалтанд Төвийн захирлын зөвшөөрлөөр танилцуулж болно.

### **Зургаа. Зөвлөлийн үйл ажиллагааны зардал**

6.1 Зөвлөлийн үйл ажиллагааны зардал нь хуралд оролцсон зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулал болон бичиг хэрэг, холбогдох байр, техник хангамж, шуудан харилцаа, холбооны болон бусад зардлаас бүрдэнэ.

6.2 Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг дараах эх үүсвэрүүдээс санхүүжүүлнэ. Үүнд:

6.2.1 Зөвлөлийн үйл ажиллагааны өдөр тутмын зардал, түүнчлэн салбарын төрийн болон улсын төсөвт байгууллага, мөн их дээд сургуулийн багш нарын эрхлэн хийсэн зөвлөмж

авах асуудлыг хэлэлцэх хурлын зардлыг “Авто замын норм нормативын сан”-аас шийдвэрлүүлэн гаргана.

6.2.2 Зөвлөлийн хурлаар төрийн бус байгууллага, хувийн хэвшил, бизнесийн байгууллага, хувь хүний оруулсан асуудлыг хэлэлцэх тохиолдолд хурлын зардлыг асуудал оруулж байгаа байгууллага, хуулийн этгээд, хувь хүн хариуцна.

6.3 Зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд хуралд оролцсон тухай бүрд нэг цагийн 55000 төгрөгийн цалин урамшууллыг хуралд оролцсон цагаар тооцож олгох ба дараах үзүүлэлтүүдийг харгалзан ажлын хөлсийг бууруулж тооцож болно. Үүнд:

- Хуралд оролцсон байдал
- Хуралд цагтаа ирсэн байдал
- Хэлэлцсэн асуудлаар үндэслэл, санал гаргасан байдал
- Хуралд бэлтгэх явцад ажлын хэсэгт орж ажиллан инженерийн тооцоо, хувилбар боловсруулсан байдал /хурлын өмнө нарийн бичгийн даргад танилцуулсан байна/

6.4 Хурлаар асуудал хэлэлцүүлэх хамгийн бага хугацаа нь 1 цаг байх бөгөөд хурлын цагийг 1; 1,5; 2 /цаг/ гэх мэтчилэн тооцож, гишүүдийн цалин урамшууллыг олгоно.

6.5 Зөвлөлийн гишүүдийн идэвхи оролцоо, ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгоно.

6.6 Хуралдсан цагийн тооцоог зөвлөлийн нарийн бичиг гаргаж, асуудал хэлэлцүүлсэн байгууллагад нэхэмжлэхээр хүргүүлнэ.

6.7 Гишүүдийн цалин урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл, орлогын татвар суутгасан дүнг Төвийн нягтлан гишүүдийн дансанд шилжүүлнэ.

6.8 Хуралд оролцоогүй гишүүнд ажлын хөлс олгохгүй.

-----ooOoo-----

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын  
Захирлын 2020 оны 8-р сарын 26-ны  
өдрийн 77 дугаар тушаалын хоёрдугаар  
хавсралт

АВТО ЗАМЫН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН,  
ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	1	Ч.Сугармаа	- Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга
Дэд дарга	2	О.Лхагвасүрэн	- “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн дарга
Гишүүд	3	С.Очирбат	- “Ай Си Ти Сайн Консалтинг” ХХК-ийн захирал, Монгол Улсын зөвлөх инженер, доктор /Ph.D/
	4	Р.Балжир	- Монгол Улсын зөвлөх инженер
	5	У.Пүрэвжав	- “Аварга зам” ХХК-ийн зөвлөх, Монгол Улсын зөвлөх инженер, доктор /Ph.D/
	6	Ч.Лхагважав	- “Лабо” ХХК-ийн зөвлөх, Монгол Улсын зөвлөх инженер, доктор (Sc.D)
	7	Б.Энхтөр	- Монгол Улсын зөвлөх эдийн засагч
	8	Ж.Батсайхан	-“Эм Си Пи Си Жи Ар” ХХК-ийн захирал, Монгол Улсын зөвлөх инженер, доктор /Ph.D/
	9	Д.Хадбаатар	- Монгол Улсын зөвлөх инженер
	10	Д.Энхтуяа	- Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Зураг төсөл, төсөв үнэ бүрдэлт, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан шинжээч, Монгол Улсын зөвлөх инженер, Тэргүүлэх төсөвчин
	11	С.Хаснавч	- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Барилга архитектурын сургуулийн дэд профессор, Монгол Улсын зөвлөх инженер, доктор /Ph.D/
	12	Х.Ганболд	- “Ю Пи” ХХК-ийн захирал, Монгол Улсын мэргэшсэн инженер
	13	Н.Пунцагноров	- “Пи Си Ди Пи” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Гүүрийн инженер,
	14	Н.Мөнхбаясгалан	- “Мөнхөд ашдын зам” ХХК-ийн захирал, Монгол Улсын мэргэшсэн инженер,
	15	Я.Баярхүү	- “Ростов” ХХК-ийн захирал, Монгол Улсын зөвлөх инженер
	16	М.Цас-Оргилмаа	- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Барилга архитектурын сургуулийн багш, доктор /Ph.D/
	17	Б.Одбаяр	- “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Эрдэм шинжилгээ, судалгаа инновацийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	18	Д.Базарсад	- “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн Стандарт норм норматив хариуцсан мэргэжилтэн

-----ooOoo-----